



**“ХОТ ТОХИЖИЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 11 сарын 18 өдөр

Дугаар А/80

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1, 108 дугаар зүйлийн 108.1 дэх хэсэг, Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын дүрмийн 2.11 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Ажилласан жилийн нэмэгдэл олгох журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан журмыг 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.
3. Уг журмын хэрэгжилтэд хяналт тавьж, хангаж ажиллахыг Захиргаа хүний нөөцийн хэлтэс (Б.Баасанбат)-т даалгасугай.

ДАРГА

Г.УУГАНБАЯР



. Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын
даргын 2025 оны 11 дүгээр сарын 18 -ны
өдрийн 18 дугаар тушаалын хавсралт



АЖИЛЛАСАН ЖИЛИЙН НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Ажилтнуудад ажилласан жилийн нэмэгдлийг олгох шалгуур, нэмэгдлийн хувь, хэмжээг тогтоож олгохтой холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2. Энэхүү журам нь Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын үндсэн ажилтан бүрд хэрэгжинэ. Үндсэн ажилтан гэдэг нь газрын бүтцэд орж батлагдсан орон тоон дээр хөдөлмөрийн хугацаагүй гэрээ байгуулан ажиллаж буй ажилтныг ойлгоно.
- 1.3. Энэхүү журмыг 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Хоёр. Ажилтны ажилласан жилийн нэмэгдлийг олгох нөхцөл

- 2.1. Ажилтнуудыг Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-т тогтвор суурьшилтай ажиллуулах, идэвхийг дээшлүүлэх, мэргэшсэн хүний нөөцийг бий болгох зорилгоор ажилтнуудад ажилласан жилийн нэмэгдэл олгоно.
- 2.2. Удаан жилийн нэмэгдлийг тухайн ажилтны хот тохижилтын газарт ажилласан хугацааг харгалзан түүний албан тушаалын үндсэн цалин дээр нэмж дор дурдсан хэмжээгээр бодож олгоно. /"Нэмэгдэл" гэж ажилтан, ажилчдын мэдлэг, ур чадвар, ажлын дадлага, туршлага, мэргэшлийн түвшин, ажилласан хугацааны, хөдөлмөрийн нөхцөл, ажлын гүйцэтгэл зэргийг харгалзан нэмэгдүүлэн олгож байгаа хөлсийг хэлнэ.

Ажилласан хугацаа (жилээр, сараар)	Албан тушаалын сарын үндсэн цалингаас бодох хувь
2 дахь жил (13 – 24 сар)	1
3 дахь жил (25 – 36 сар)	2
4 дэх жил (37 – 48 сар)	3
5 дахь жил (49 – 60 сар)	4
6 дахь жил (61 – 72 сар)	5
7 дахь жил (73 – 84 сар)	6
8 дахь жил (85 – 96 сар)	7
9 дэх жил (97 – 108 сар)	8
10 дахь жил (109 – 120 сар)	9

11 дэх жил (121 – 132 сар)	10
12 дахь жил (133 – 144 сар)	11
13 дахь жил (145 – 156 сар)	12
14 дэх жил (157 – 168 сар)	13
15 дахь жил (169 – 180 сар)	14
16 дахь жил (181 – 192 сар)	15
17 дахь жил (193 – 204 сар)	16
18 дахь жил (205 – 216 сар)	17
19 дэх жил (217 – 228 сар)	18
20 дахь жил (229 – 240 сар)	19
21 дэх жил (241 – 252 сар)	20
22 дахь жил (253 – 264 сар)	21
23 дахь жил (265 – 276 сар)	22
24 дэх жил (277 – 288 сар)	23
25 дахь жил (289 – 300 сар)	24
26 ба түүнээс дээш жил (301 ба түүнээс дээш сар)	25

2.3. Ажилтнуудын ажилласан хугацааг тогтоох үндсэн баримт нь газрын даргын ажилд авах тухай тушаал байх бөгөөд энэхүү тушаал гарсан өдрөөс эхэлж ажилласан жилийг тоолно. /2016 оны ИТХТ-ийн 14 тогтоол/

2.4. Ажилласан жилийг энэхүү журмын 2.3-т заасны дагуу газрын Дотоо ажил, хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн тодорхойлж, Захиргаа хүний нөөцийн хэлтсийн даргаар хянуулснаар, газрын даргын тушаалыг үндэслэж нэмэгдлийг олгоно.

2.5. Ажилтны ажилласан хугацааг сараар тооцон гаргах ба энэ нь тухайн газар тасралтгүй ажилласан байх зарчмыг баримтална.

2.6. Ажлаас чөлөөлөгдөөд эргэн орж байгаа болон ажилласан хугацаа нь тасарсан бол ажилтны Хот тохижилтын газарт ажилласан хугацааг дахин шинээр тооцно.

2.7. Газрын даргын тушаалаар чөлөө авсан, хүүхэд асрах чөлөө авсан болон хуульд заасны дагуу ажлын байр нь хэвээр хадгалагдаж байгаа ажилтанд тухайн хугацааг ажилласан жилд хамааруулан тооцно.

2.8. Дотоод ажил, хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтний ажилласан жилийн тооцоог жилд 1 удаа шинэчлэх бөгөөд жил бүрийн 12 сарын 25-ны өдрийн

дотор гаргаж Газрын даргын тушаалаар батлуулж, ажилтанд удаан жилийн нэмэгдлийг олгоно.

2.9. Удаан жилийн нэмэгдлийг Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын жил бүрийнхээ төсөвт тусгаж олгоно.